




8th Story

**Синагогийн ахлагчийн охин
ба цус алддаг өвчтэй
хүнийг эдгээв!**

The Sick and Sleeping



Синагогийн ахлагчийн охин ба цус алддаг өвчтэй хүнийг эдгээв!

– 8th Story –

- | | |
|--------------|---|
| Өгүүлэгч | Есүс болон шавь нар нь Есүсийн төрсөн нутаг Назар руу явлаа. Тэнд ч гэсэн олон хүн хүрч ирээд Есүсийн сургаалыг сонсож байлаа. Нэгэн өдөр Есүс гүвээний бэлд сургаалаа зааж байх үед нэгэн хүн яаравчлан гүйж ирэв. |
| Иаир | Эзэн, Эзэн минь ~~ |
| Өгүүлэгч | Энэ хүний нэрийг Иаир гэдэг. Тэр нутгийн синагогийн ахлагч байсан хүн. |
| Иаир | Эзэн минь, миний охин ... миний охин үхэж байна. Харин Эзэн Та надтай хамт явж гараа хүүхдийн минь толгой дээр тавьж залбирч өгвөл заавал эдгэрнэ гэдэгт итгэж байна. |
| Есүс | За тэгье ээ. Явцгаая |
| Өгүүлэгч | Есүс Иаирыг даган замд гарлаа. Есүсийн араас үй олон хүн дагаж ирэв. Тэдний дунд нэгэн эмэгтэй байв. 12 жилийн турш өвдөж шаналсан хүн юм. Тэр эмэгтэй ч гэсэн Есүсээр эдгээлгэхийг хүссэн. Есүс рүү дөхөж очих гэсэн боловч хүмүүс дэндүү их байлаа. Тиймээс өвдөг сөхрөн хүмүүсийн хөлийн завсараар мөлхөж очоод Есүст хүрэх гэж байв. Зүгээр Есүст хүрэх л юм бол өвчин нь бүрэн эдгэнэ гэж итгэж байсан. Тиймээс үнэхээр Есүсийн хувцаснаас хальт барьсан бөгөөд Есүс алхаагаа зогсоон эргэж харав. |
| Есүс | Хэн миний хувцаснаас барьсан бэ? |
| Иохан | аа? |
| Олон түмэн 1 | Би биш |
| Олон түмэн 2 | Би ч бас биш дээ? |
| Олон түмэн 3 | Би тэгээгүй ээ. |
| Петр | Багшаа, хүмүүс ингэж их бүчиж шахаад Тантай наалдах шахам ойрхон байна. Гэтэл хэн Таны хувцаснаас барьсан юм бол гэж асуувал яаж мэдэх билээ? |
| Өгүүлэгч | Харсанчлан Есүс эдгээх хүч Өөрөөс нь гарахыг мэдэрсэн. Тиймээс сая өөрт нь хүрсэн хүний өвчин эдгэсэн гэдгийг ч мэдэж байв. Есүс эргэн тойрноо харахад нөгөөх эмэгтэй дөхөж ирэн Есүст мөргөлөө |

гЦус алддаг өвчтэй хүн

Би ... би байна. Эзэн Танаас зуурсан нь би байна. Би 12 жилийн турш өвдөж байна. Очиж үзээгүй эмнэлэг, уулзаагүй эмч байхгүй, жаахан ч эдгэрсэнгүй. Мөнгөө ч бүгдийг нь барсан. Би өнөөдөр Эзэн Тантай уулзаж үгийг чинь сонсоод, Тантай уулзах л юм бол эдгэрнэ гэсэн итгэл төрсөн учраас тэгсэн юм.

Есүс

Охин минь, чиний итгэл чамайг аварлаа. Тайван явагтун. Одоо үүнээс хойш өвчнөөс болж зоволгүй эрүүл саруул байх болно.

гЦус алддаг өвчтэй хүн

Өгүүлэгч

Тиймээ, Эзэн баярлалаа. Талархаж байна.

Зарц

Есүс Иаирыг даган үргэлжлүүлэн гэр рүү нь явлаа. Гэрт нь очих үед зарц нь гарч ирээд Иаир руу гүйж очлоо. Эзэн таны охин ... үхчихлээ. Одоо юу ч хийх нэмэргүй болсон.

Иаир

болохгүй ээ ... болохгүй ...

Есүс

Бүү айгтун, Иаир аа. Итгэхэд л болно. Петр, Иаков, Иохан та нар дагаад ороод ир.

Олон түмэн 1

ээхээ ... нэг алхам хоцорчихож ...

Өгүүлэгч

Есүс гурван шавьтайгаа гэр дотогш орох үед олон хүн уйлж байлаа.

Олон түмэн 2

аль хэдийн үхчихжээ ... хүүхэд үхсэн байна. Итгэмээргүй юм. Ийм залуугаараа ...

Есүс

Та нар яагаад бүгд уйлна вэ? Энэ хүүхэд унтаж байна.

Өгүүлэгч

Есүс энэ үгийг хэлтэл хүмүүс бүгд шоолж уурлан дооглож байсан.

Олон түмэн 3

Тоглоод байгаа юмуу? Яаж тийм үгийг хэлж чадна вэ? үхсэн шүү дээ, үхсэн.

Есүс

Эцэг эх болон шавь нар л үлдээд бүгд гарцгаана уу!!

Олон түмэн

Юм мэддэг л юм байх даа? (дуурайн) “унтаж байна” инээдтэй юм!!

Есүс

Талита кум, «Бос, бяцхан охин минь, Би чамд хэлж байна~!!

Өгүүлэгч

Есүс айлдмагц охин боссон. Тэгээд алхаж эхэлсэн.

Иаирын эхнэр

өө, үр минь .. Эзэн минь баярлалаа, Тандаа талархаж байна

Шавь нар

Пөөх~!!, гайхалтай ... гайхамшигтай~!!

Есүс

Чиний итгэл чамайг аварлаа. Энэ явдлын тухай хэнд ч бүү ярь. Ойлгов уу?

Иаирын эхнэр

Ойлголоо





Есүс

Петр, Иаков, Иохан~!! Та нар ч бас хэнд ч бүү ярь ойлгов уу?

Шавь нар

За тэгэлгүй яахав. ойлголоо

Есүс

Энэ хүүхдэд идэх юм өг

Өгүүлэгч

Есүс болон шавь нар нь Иаирын гэрээс явсаны дараа энэ мэдээ улс даяар тархжээ. Тэгээд олон хүн гайхаж шагшран үнэхээр энэ Есүс гэж хэн болохыг мэдэхийг хүссэн.